2018 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ТАНИЛЦУУЛГА

2018.04.02 Улаанбаатар хот

*Нэг.**ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ДУУДЛАГА, БҮРТГЭГДСЭН ОСОЛ***

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018 оны эхний улиралд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг 10174 гомдол, мэдээлэл бүртгэгдсэний 6835 буюу 67,2 хувь нь замын цагдаагийн албанд /нийслэл/ бүртгэгдэн шалгагдсан байна.

Улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй дуудлага 18542-г хүлээн авч шийдвэрлэсэн байна. Зам тээврийн ослын шинжтэй дуудлагын тоо нь өнгөрсөн оны үзүүлэлтээс улсын хэмжээнд 19.6 хувиар, Улаанбаатар хотод 18.1 хувиар буурчээ.

Улсын хэмжээнд 7568 зам тээврийн осол бүртгэгдсэний 693 буюу 9.2 хувь нь орон нутгийн замд, 6875 осол Улаанбаатар хотын замд гарсан осол байна.

Улаанбаатар хотын замд гарсан 6875 ослын 589 буюу 8.6 хувь нь хүн гэмтсэн осол, 6286 нь эд материалын хохиролтой осол бүртгэгджээ.





Улсын хэмжээнд хүлээн авсан 50389 гомдол, мэдээллийн 10174 буюу 20.2 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гомдол мэдээлэл байна.

Нийслэлд хүлээн авсан Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гомдол, мэдээллийн 208 буюу 3.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл байхад 96.9 хувь нь захиргааны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.

Зам тээврийн ослын тоон үзүүлэлтүүдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан авч үзвэл:

БУУРСАН үзүүлэлт:

- Зам тээврийн ослын шинжтэй дуудлага 19.6 хувь,
- Бүртгэгдсэн зам тээврийн осол 30.5 хувь,
- ХАБТХАЖЭГэмт хэрэг 28.0 хувь,
- Гэмт хэргийн улмаас нас барсан хүн 33.7 хувь,
- Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 27.5 хувь,
- Хүүхэд өртсөн осол 11.2 хувь,
- Согтуугаар автомашин жолоодсон зөрчил илрүүлэлт 4.9 хувь,
- Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах арга хэмжээ 9.7 хувь,
- Зарлагдсан тээврийн хэрэгслийн илрүүлэлт 32.8 хувь
- Цагдаагийн нийтлэг үүргээр илрүүлсэн зөрчил 27.0 хувь,
- Жолоочийн оноо хассан тохиолдол 18.0 хувь,

ӨССӨН үзүүлэлт:

- Илрүүлсэн зөрчил 22.2 хувь,
- Зам тээврийн ослын улмаас учирсан хохирол 84.3 хувь,
- Нөхөн төлүүлэлт 2,1 дахин,
- Торгуулсан хүний тоо 2.8 хувь,
- Баривчлах арга хэмжээ авагдсан хүн 2,1 дахин,
- Эрэн сурвалжлалтын сангийн илрүүлэлт 27.3 хувь байна.

Бодит нас баралт улсын хэмжээнд 8.4 хувиар буурсан ч орон нутагт 11.8 хувийн бууралттай, нийслэлд 5,3 хувийн өсөлттэй байна.

Зам тээврийн ослын үзүүлэлт /Улаанбаатар 2018 оны 1 дүгээр улирал/

д/д	Дүүрэг	Хүлээн авсан ослын дуудлага	*нийт дуудлагад эзлэх хувь*	Бүртгэгдсэн зам тээврийн осол	*нийт осолд эзлэх хувь*	Эд материалын хохиролтой осол	*нийт эд материалын хохиролд эзлэх хувь*	Хүн гэмтсэн осол	*нийт хүн гэмтсэн осолд эзлэх хувь*
1	ХУД	2086	*11.7*	1035	*15.2*	980	*15.7*	55	*9.3*
2	БГД	3573	*20.0*	1404	*20.6*	1298	*20.8*	106	*18.0*
3	БЗД	4618	*25.9*	1564	*22.9*	1426	*22.9*	138	*23.4*
4	СБД	2774	*15.5*	827	*12.1*	739	*11.9*	88	*14.9*
5	СХД	2971	*16.6*	1162	*17.0*	1034	*16.6*	128	*21.7*
6	ЧД	1803	*10.1*	809	*11.9*	739	*11.9*	70	*11.9*
6 дүүрэг		***17825***	*99.9*	***6801***	*99.6*	***6216***	*99.7*	***585***	*99.3*
7	БН	13	*0.1*	13	*0.2*	11	*0.2*	2	*0.3*
8	БХ	3	*0.0*	3	*0.0*	3	*0.0*	0	*0.0*
9	НА	8	*0.0*	8	*0.1*	6	*0.1*	2	*0.3*
УБ хот		***17849***	*100.0*	***6825***	*100.0*	***6236***	*100.0*	***589***	*100.0*

*Хоёр.**ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ***

Улсын хэмжээнд 2018 оны 1 дүгээр улиралд бүх төрлийн 10753 гэмт хэрэг бүртгэгдсэний дотор Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 291 буюу 2.8 хувийг эзэлж байна.



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 291 гэмт хэргийн улмаас 59 хүн нас барж,190 хүн гэмтсэн статистик үзүүлэлт гарсан ч бодит нас баралт 87-д хүрчээ.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 46,4 хувь нь нийслэлд, 53.6 хувь нь орон нутагт бүртгэгджээ.

Энэ төрлийн 291 гэмт хэргийн:

- ✓ 278 буюу 95.5 хувь нь хөнгөн,
- ✓ 13 буюу 4.5 хувь нь хүнд хэрэг байна.

Бүртгэгдсэн 291 гэмт хэргийн 70 буюу 24.1 хувийг илрүүлэн яллагдагчаар татсан байхад 201 гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэн ажиллагаа хийгдэн шалгаж байна.



Гурав. ***ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ***

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 87 хүн нас барж /бодит нас баралтын тоо/, 863 хүн гэмтэж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 4 тэрбум 31 сая төгрөгийн хохирол учирсан байна. Иргэдэд учирсан хохиролын 3 тэрбум 463,5 сая төгрөгийн буюу 85.9 хувийг нөхөн төлүүлжээ.

Орон нутаг

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон ослын тохиолдол 80 бүртгэгдсэний 77.5 хувь нь орон нутгийн замд гарсан ослын тохиолдол эзэлж байна.

Орон нутгийн замд 67 хүний амь нас хохирсон нь улсын хэмжээнд амь насаа алдсан хүний 77.0 хувийг эзэлж байна.





Улаанбаатар хот

Нийслэлийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар 20 /бодит/ хүн амь насаа алдаж, гэмт хэргийн улмаас 119 хүн, зам тээврийн ослын улмаас 678 хүн гэмтэл бэртэл авчээ.



Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 87 хүн /бодит нас баралт/, гэмтсэн 863 хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрийг авч үзвэл:

Улсын хэмжээнд:

- **Явган зорчигч** – 21 хүн амь насаа алдаж, 503 гэмтсэн
- Жолооч – 34 хүн амь насаа алдаж, 104 гэмтсэн

- Тээврийн хэрэгслээр зорчигч – 33 хүн амь насаа алдаж, 317 гэмтсэн
- Дугуйтай хүн – 4 гэмтсэн

Улаанбаатар хотод:

- **Явган зорчигч** – 12 хүн амь насаа алдаж, 467 гэмтсэн
- Жолооч – 2 хүн амь насаа алдаж, 66 гэмтсэн
- Тээврийн хэрэгслээр зорчигч – 6 хүн амь насаа алдаж, 207 гэмтсэн
- Дугуйтай хүн – 4 гэмтсэн

Гэмт хэргийн улмаас гэмтсэн 530 хүний гэмтлийн зэргээс харахад:

- Хөнгөн гэмтэл 22 буюу 11.6 %,
- **Хүндэвтэр гэмтэл** 129 буюу 67.9 %,
- Хүнд гэмтэл 39 буюу 20.5 %

Зам тээврийн ослын улмаас тодорхой хэмжээний гэмтэл бэртэл авсан 863 хүн бүртгэгдсэн байна.

ХҮНИЙ АМЬ НАС ХОХИРСОН ОСОЛ /ГЭМТ ХЭРЭГ/

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон осол /хэрэг/ 80 бүртгэгдсэнээс орон нутгийн замд 62 буюу 77.5 хувийг эзэлсэн байна.



Хүний амь нас хохирсон 80 ослын /хэрэг/ шалтгаан нөхцлийн байдлаас авч үзвэл:

Хүний амь нас хохирсон осолд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол нийт ослын 31,3 хувийг, анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсоноос 18,8 хувь, хурд хэтрүүлэн явсанаас 16,3 хувь, явган ба дугуйтай хүний буруутай үйлдлээс шалтгаалсан осол 11,3 хувийг тус тус эзэлжээ.



Хүний амь нас хохирсон ослын шалтгаан нөхцлөөс үзвэл: Орон нутгийн замд онхолдох хэлбэрээр өдрийн цагт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, хурд хэтрүүлсэн, анхаарал болгоомжгүйгээс дийлэнх осол бүртгэгджээ.

Дөрөв. ***ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ШАЛТГААН***

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 7511 зам тээврийн ослын 7400 буюу 98.5 хувь нь жолоочийн буруугаас, 95 буюу 1.3 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, замын нөхцөл байдлаас 16 буюу 0.2 хувь нь гарчээ.

№	ШАЛТГААН	УЛС	эзлэх %	ХОТ	эзлэх %	ОРОН НУТАГ	эзлэх %
1	Жолоочийн буруутай үйлдэл	7400	98.5	6809	98.7	591	96.3
2	Явган зорчигчийн буруутай үйлдэл	95	1.3	80	1.2	15	2.4
3	Замын нөхцөл	16	0.2	8	0.1	8	1.3

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгааны 98.9 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан ба хажуу хоорондын зай тохируулаагүй, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, эгнээ байр буруу эзэлсэнээс шалтгааалсан осол дийлэнх хувийг эзэлж байгаа нь төв суурин газарт бүртгэгдсэн осол их байгаатай холбоотой юм.

Зам тээврийн осол гарсан шалтгааныг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад:

БУУРСАН :

- Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөнөөс 4.4 хувиар
- Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон 77.7 хувиар
- Бүрэн бус тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон 3.7 хувиар
- Зогсоох арга хэмжээ аваагүйгээс 82.6 хувиар,
- Гэрэл дохио зөрчсөн 20.0 хувиар,
- Эргэх үйлдэл буруу гүйцэтгэсэн 59.6 хувиар,
- Хажуу хоорондын зай тохируулаагүйгээс гарсан осол 20.5 хувиар
- Эгнээ байр буруу эзэлсэн 54.0 хувиар
- Явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан осол 58.3 хувиар

ӨССӨН:

- Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу гүйцэтгэсэн 31.4 хувиар,
- Эсрэг урсгалд орсон 3.7 хувиар,
- Согтуугаар автомашин жолоодсоноос гарсан осол 5.3 хувиар
- Хурд хэтрүүлсэнээс гарсан осол 76.1 хувиар

Зам тээврийн ослын шалтгаан дотроос хамгийн их хор уршиг учруулдаг шалтгаан нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлэх тохиолдол байдаг. Эхний улирлын байдлаар дээрх 2 шалтгаан өссөн дүнтэй харагдаж байна.





Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын хувьд улсын хэмжээнд 95 буюу нийт бүртгэгдсэн ослын 1.3 хувийг эзэлсэн байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс бүртгэгдсэн зам тээврийн ослын 84,2 хувь нь нийслэлд бүртгэгдсэн.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 47 буюу 49.5 хувийг явган зорчигчийн буруу, 12 буюу 12.6 хувийг эцэг, эх, асран хамгаалагчийн буруутай үйлдэл, 36 буюу 37.9 хувь нь явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалсан байна.



Явган зорчигчийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцдоггүй, согтуугаар хөдөлгөөнд оролцож байгаа нь зам тээврийн ослын хохирогч болсоор байна.

Тав. ***ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ХЭЛБЭР***

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 7511 зам тээврийн ослын 6704 буюу 89.3 хувь нь мөргөлдөх, 508 буюу 6.8 хувь нь явган зорчигч мөргөх, 135 буюу 1.8 хувь нь онхолдох, 115 буюу 1.5 хувь үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/ 3 осол зорчигч унагах, 4 дугуйтай хүн мөргөх, 10 осол мал, амьтан дайрах хэлбэрээр бүртгэгдсэн байна.



Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол гарсан хэлбэрийг авч үзвэл: онхолдох хэлбэрээр гарсан ослын 84.4 хувийг орон нутагт гарсан осол эзэлж байхад явган зорчигч мөргөсөн ослын 89.6 хувь нь нийслэлд бүртгэгджээ.

№	ХЭЛБЭР	УЛС	эзлэх %	ХОТ	эзлэх %	ОРОН НУТАГ	эзлэх %
1	Мөргөлдөх	6704	89.3	6338	91.9	366	59.6
2	Явган хүн дайрах	508	6.8	455	6.60	53	8.6
3	Үл хөдлөх зүйл мөргөх	115	1.5	70	1.01	45	7.3
4	Онхолдох	135	1.8	21	0.30	114	18.6
5	Мал, амьтан дайрах	10	0.1	5	0.07	5	0.8
6	Зорчигч унагах	3	0.0	1	0.01	2	0.3
7	Дугуйтай хүн мөргөх	4	0.05	4	0.058		0.0
8	Бусад	32	0.43	3	0.043	29	4.7

Зургаа. ***ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ГАРИГ, ЦАГ ХУГАЦАА***

Осол гарсан цагийн бүртгэлээс харвал:

- 06.00-12,00 цагийн хооронд 1133 буюу 15.1 хувь,
- 12.00-18.00 цагийн хооронд 2498 буюу 33.3 хувь,
- 18.00-22.00 цагийн хооронд **2599 буюу 34.6 хувь,**
- 22.00-06.00 цагийн хооронд 1281 буюу 17.0 хувь нь тус тус бүртгэгджээ.

Осол их бүртгэгдэж байгаа цагийн байдлаас харахад 18.00-22.00 цагт дийлэнхи хувийг эзэлсэн тоон үзүүлэлт гарсан байна. Өнгөрсөн оны үзүүлэлтэд 12.00-18.00 цагийн хооронд бүртгэгдсэн осол дийлэнх хувийг эзэлж байсан байна.





Долоо. ***ХҮҮХЭД ӨРТСӨН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ***

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн осол 150 бүртгэгдэж ослын улмаас 3 хүүхэд амь насаа алдаж, 139 хүүхэд гэмтэл авснаас 23 хүүхэд хүндэвтэр, хүнд гэмтжээ. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад хүүхэд өртсөн ослын гаралт 11.2 хувиар, гэмтсэн хүүхдийн тоо 32.4 хувиар, нас барсан хүүхэд 76.9 хувиар тус тус буурчээ.

Нийт нас барсан, гэмтсэн хүний тоонд хүүхэд нас барж, гэмтсэн үзүүлэлтийг харьцуулан үзвэл:





Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний 14.8 хувийг хүүхдийн нас баралт, гэмтсэн хүний 18.2 хувийг хүүхэд тус тус эзэлсэн үзүүлэлт гарчээ.

Орон нутагт зам тээврийн ослын улмаас 3 хүүхэд амь насаа алдаж, нийт гэмтсэн хүүхдийн 62.6 хувийг нийслэлд гарсан осол эзэлж байна.

Улсын хэмжээнд хүүхэд өртсөн ослын тоон үзүүлэлтээс харахад: 103 явган зорчигч, 51 тээврийн хэрэгслээр зорчигч, 2 унадаг дугуйгаар зорчигч хүүхэд амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ.





Нийслэлд явганаар замын хөдөлгөөнд оролцож осолд өртсөн 12 хүртэл насны хүүхдийн 40.0 хувь нь насанд хүрсэн харгалзах хүнтэй замын хөдөлгөөнд оролцсон бол 50.0 хувь нь харгалзах хүнгүй ганцаараа, 10.0 хувь нь насанд хүрээгүй найз, ах, эгч дүү нартайгаа замын хөдөлгөөнд оролцож байсан байна.

Найм. ***СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ***

2018 оны 1 дүгээр улиралд улсын хэмжээнд жолооч архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс 159 зам тээврийн осол бүртгэгдэж түүний улмаас 36 хүн амь насаа алдаж 71 хүн гэмтэл бэртэл авчээ. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн осол 23.5 хувиар, хүний амь нас хохирсон тохиолдол 29,4 хувиар тус тус буурчээ.

№	Он	Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос гарсан бүх осол, хэрэг			
		улс	*эзлэх хувь*	*хот*	*эзлэх хувь*
1	**2018 оны 1 дүгээр улирал**	159	2.1	88	1.3





Явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцож амь насаа алдаж, бэртэж гэмтсэн тохиолдол 36 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 56.6 хувийн бууралттай байна. Явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцож зам тээврийн осолд өртсөн 36 тохиолдлын 32 буюу 88.9 хувь нь нийслэлийн замд бүртгэгдсэн осол байна.

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд гудамж замын хяналт шалгалтаар согтууруулах ундааны зүйл хэрэглэн замын хөдөлгөөнд оролцсон 6369 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс илрүүлэлт 4.9 хувиар буурчээ.

№	Он	Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн илрүүлэлт							
		Илрүүлсэн зөрчил		*үүнээс*					
				эрхийн үнэмлэхтэй		эрхээ хасуулсан жолооч		эрхийн үнэмлэхгүй	
		улс	*хот*	*улс*	*хот*	*улс*	*хот*	*улс*	*хот*
1	**2018 оны 1 дүгээр улирал**	6369	3432	5473	3149	548	228	348	55

Арав. ***ЖОЛООЧИЙН ЗӨРЧЛИЙН ОНОО***

Монгол улсад тээврийн хэрэгслийн жолоочид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, тэдний сахилга, хариуцлагыг сайжруулах, гаргасан зөрчилд оноо тооцох, зөрчил гаргаагүй тохиолдолд урамшуулах асуудлыг зохицуулах зорилготой "Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам"-ыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад баримталж байна.

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд 42315 жолоочийн оноо хасагдаж, 737 жолоочийн зөрчлийн оноо дуусч эрх түдгэлзэн 191 жолооч заавар журмын дагуу эрхээ сэргээлгэсэн байна.

Улсын хэмжээнд жолоочийн зөрчлийн оноо хасагдсан хамгийн их зөрчил нь хамгаалах бүс хэрэглээгүй, гэрэл дохио зөрчсөн зөрчилд хасагдсан байхад зам тээврийн осол үйлдсэн буюу Зөрчлийн хуулийн 14.7.51 заалтаар 5850 жолоочийн 5 оноо хасагдсан байна.

ОНОО ХАСАГДСАН ТОХИОЛДЛЫН ТОО	ОНОО СЭРГЭЭГДСЭН ТОХИОЛДЛЫН ТОО	ОНОО ДУУССАН	НӨХӨН ОЛГОСОН
42315	191	737	48

“Жолоочийн оноо тооцох журам”-ын 3.1-д “Зөрчлийн бүртгэлийн оноо хасагдсанаас хойш 1 жилийн хугацаанд дахин замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчөөгүй жолоочийн хамгийн сүүлд хасагдсан оноог сэргээнэ” гэж заасны дагуу 77825 жолоочийн онооны урамшуулал олгогдсон байна.

ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБА